



ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 01 сарын 30 өдөр

Дугаар А/48


Чойр

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3, 7 дугаар зүйлийн 7.3, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.4, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2024 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн 03 дугаар хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1."Цагаан сарын баярын өдөр"-ийг тохиолдуулан Говьсүмбэр аймгаас төрсөн "Монгол Улсын Гавьяат" цолтон, ахмад дайчинд хүндэтгэл үзүүлэх арга хэмжээнд зарцуулах 1,920,000 (нэг сая есөн зуун хорин мянга) төгрөгийн төсвийг хавсралтаар баталсугай.

2.Дээрх арга хэмжээнд шаардагдах зардлыг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Содном)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА  Г.БАТСУУРЬ

4212400113

Аймгийн Засаг даргын 2024 оны
01 дүгээр сарын 30 -ны өдрийн
А/УХ дугаар захирамжийн хавсралт

ГОВЬСҮМБЭР АЙМГААС ТӨРСӨН "МОНГОЛ УЛСЫН ГАВЬЯАТ" ЦОЛТНУУД, АХМАД
ДАЙЧИНД ОЛГОХ ГАРЫН БЭЛГИЙН ТӨСӨВ

№	Материалын нэр	Хэмжих нэгж	Тоо/ш	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	Календарь	ш	15	4,500	67,500
2	Торго	м	15	60,000	900,000
3	Бэлэгний уут	ш	15	3,500	52,500
4	Чацаргана	кг	15	18,000	270,000
5	Сүү	л	15	6,000	90,000
6	Хадаг	ш	15	8,000	120,000
7	Чихэр	кг	15	20,000	300,000
8	Ахмад дайчинд хүндэтгэл үзүүлэх				120,000
НИЙТ ҮНЭ				120,000	1,920,000

